

**ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 08 дугаар сарын 29-ний өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-2</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>3-22</i>
<hr/>	
<i>1. Хянан шалгах түр хорооны даргыг сонгох</i>	<i>3-22</i>

Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороо
/Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий/-ны 2023 оны 08 дугаар сарын 29-ний өдөр /Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 72.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 40 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Г.Ганболд;

Чөлөөтэй: Б.Энхбаяр.

Нэг.Хянан шалгах түр хорооны даргыг сонгох

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Дэд дарга Ц.Батбаатар, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, Хяналт шалгалтын хэлтсийн референт Ж.Лхагвасүрэн, Ж.Монголжингоо нар байлцав.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан, С.Ганбаатар, Д.Ганбат, М.Оюунчимэг нар санал хэлж, Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар, С.Ганбаатар нарыг Түр хорооны даргад нэр дэвшүүлэв.

Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Б.Жаргалмаа, Д.Ганбат, Ж.Сүхбаатар, О.Цогтгэрэл, Б.Энх-Амгалан, Т.Доржханд нарын тавьсан асуултад нэр дэвшигч, Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Х.Нямбаатар нар хариулж, тайлбар хийв.

Д.Ганбат: Хянан шалгах түр хороо /Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд олон нийтийг мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий/-ны даргад Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатарыг нэр дэвшүүлснийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 4

Бүгд: 9

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Түр хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатарыг дэмжсэн тул Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатарыг дэмжих санал хураалт явуулаагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат “Түр хорооны даргыг сонгох тухай” Түр хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар үг хэлэв.

Д.Ганбат: “Түр хорооны даргыг сонгох тухай” Түр хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Түр хорооны дарга Х.Нямбаатар 12 цаг 53 минутаас хуралдааныг даргалж, үг хэлэв.

Уг асуудлыг 13 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Түр хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 20 минут үргэлжилж, ирвэл зохих 11 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 81,8 хувийн ирцтэйгээр 13 цаг 00 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Д.ГАНБАТ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 08 дугаар сарын 29-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим, 11 цаг 40 минут

ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Ганбат: Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. Өнөөдөр Монгол Улсын Их Хурлын 2023 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 63 дугаар тогтоолоор байгуулагдсан Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ, худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул өнөөдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Ингээд Түр хорооны гишүүд маань нийт 11 гишүүнд байгаа юм байна. Бат-Амгалан гишүүн ирсэн байна. Ганболд гишүүн ирээгүй байна. Жаргалмаа гишүүн ирсэн байна. Нямбаатар гишүүн ирсэн юм байна. Оюунчимэг гишүүн ирсэн байна. Сүхбаатар гишүүн ирсэн байна. Баттөмөрийн Энхбаяр гишүүн ирээгүй байгаа юм байна. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн ирсэн байна. Тэгээд би ирчихсэн байна. Доржханд гишүүн ирээгүй байна. Цогтгэрэл гишүүн ирсэн ингээд 72,7 хувийн ирцтэй байна.

Ингээд та бүхэнд өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн

оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ, худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны даргыг сонгох юм байна. Хэлэлцэх асуудлаа баталдаг билүү. Батлах шаардлагагүй биз дээ. Хэлэлцэх асуудал нь ийм асуудал байна. Энэ асуудал дээр саналтай, асуулттай гишүүд байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудлаа батлах уу. Баталъя. 1 л асуудал байгаа юм байна. Гараа өргөчих юм уу, яах юм. Кнопоор юм уу. Ойрд хурал хийгээгүй болохоор. Ингээд энэ нүүрсний түр хорооны даргад нэр дэвшүүлэх саналтай гишүүд байна уу? Бат-Амгалан гишүүн байна. Ганбаатар гишүүн байна. Ингээд Бат-Амгалан гишүүн саналаа хэлнэ үү.

Э.Бат-Амгалан: Нүүрсний хянан шалгах түр хороо байгуулах тухай өнөөдөр бас орж, хэлэлцэж байна. Энэ бас нэлээдгүй хэдэн сарын хугацаа явчихсан, заавал үр дүн гарах ёстой Монгол улсын эдийн засагтай, хөрөнгө оруулалттай тэгээд ер нь Монгол Улсын бүхий л цаашдын ирээдүйн асуудал тай холбоотой ийм түр хороо нэртэй боловч богино хугацаанд яаралтай ажиллах ийм шаардлагатай түр хороог байгуулах гэж байна. Тэгээд энэ түр хороонд байгаа хүмүүсийн нэрсийг харж байна. Би түр хорооны даргаар Хууль зүйн сайд, Их Хурлын гишүүн Нямбаатар сайдыг санал болгож байна. Яагаад гэвэл бас мэдээлэлд ойрхон энэ чиглэлийнхээ ажлууд дээр ажиллахад арай амар хялбар болох болов уу гэж ингэж бодож байна. Нямбаатар сайдыг Түр хорооны даргад санал болгож байна.

Д.Ганбат: Бат-Амгалан гишүүнд баярлалаа. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Нүүрсний асуудлыг Монголын ард түмэн тэр чигээрээ хүлээж байгаа. Ер нь техникийн асуудлыг улс төрийн аргаар шийдэж болохгүй гэж үг байдаг. Энэ бол маш том Засгийн газар, улс төрчид оролцсон маш том бүлэг гэмт хэрэг. Хэдэн 100 сая, хэдэн 10 сая тонн нүүрс хилээр гарч байхад ерөөсөө ажиглаагүй. Тухайн үеийн цагдаа, шүүх, прокурор, АТГ бүгд оролцсон. Бас хам хэрэгтнүүд. Энэ чинь гар утас хулгайлаагүй шүү дээ. Хэдэн мянган тонны, хэдэн мянган машин хилээр гарч байгааг улс даяараа нүдэн дээр нь маш том мафийн үйл ажиллагаа энэ бол. Энийг Монголын ард түмэн харж байгаа. Тэр зарим нь 40 хэдэн их наяд гэлээ. Энэ чинь 1 их наяд чинь 10 сая хонь шүү дээ. 40 их наяд гэдэг чинь Монголын нийт хонийг 32,333 дахин үржүүлсэнтэй адилхан шүү дээ. Ийм том хулгайг өнөөдөр ярьж байгаа. Тэгэхээр 1 дүгээр зүйл Засгийн газрын гишүүдээс энд орж болохгүй ээ. Өөрөө өөрийгөө шалгана гэж байхгүй. Сүүлийн 8 жил, хэдэн жилийн маш олон жилийн хулгай. Гочоогийн Ганболд бол маш сайн ажилласан. Сайн ажилласан учраас харин ингээд гацаад, ажиллаж чадахаа болиод, дараагийнх руугаа орж байгаа. Хэд хэдэн удаа бид нар энэ сонголыг хийе, асуудлаа гаргаж тавья гэж ярьсан.

Би олон юм нуруаад яах вэ, олон материал надад байна. Энэ гүйцэтгэлийн аудитын тайлан Үндэсний аудитын газрын гүйцэтгэлийн аудитын тайлан. Би олон юм ярихгүй. Ганцхан өгүүлбэр уншъя. Хуудас 47 дээр 3.10. Эрдэнэс Тавантолгой ХК-ийг засаглалын хувьд зах зээлийн зарчмаар ажиллуулахгүй. Төр засаг, Ерөнхийлөгч, Засгийн газрын шийдвэрээр үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс нөлөөлж, компанийн орлого ашгаар ТЭЗҮ-д тусгасан ордыг цогцоор нь үр ашигтай ажиглах, нэгдсэн төлөөлөл, төлөвлөлтийн хүрээний дэд

бүтэц, бүтээн байгуулалтын төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэхгүйгээр нийгмийн болон төсвийн шинж чанартай асуудалд зарцуулсан нь ордын үнэ цэнийг бууруулах, насжилтыг богиносгон сорчилж ашиглахад хүргэсэн байна. Энэ бол том том улс төрчид сонгуулийн мөнгөө босгосон гэдэг нь харагдаж байна. Би олон юм яриад яах вэ. Одоо бүр энэ янзаараа хөөрхий муу Ганхуяг том улс төрчдийнхөө үгэнд орсноороо л өнөөдөр шоронд ороод, одоо шонд өлгөгдөх гэж байх шиг байна. Би цаашаа зөндөө олон нарийн зүйлүүдийг унших байх 3.9 дээр нь жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах, компанийн нэр хүндийг өсгөх тал дээр юу ч хийгээгүй. Монголын ард түмний тэр хувьцаа гэдэг юм бол зүгээр жүжиг. Нөгөө шилний цаанаас чихэр долоолгоно гэдэг шиг юм болж байгаа. Ингээд техникийн олон асуудлуудыг шийдэх ёстой байгаа. Шинжээч, эксперт бие даасан хөндлөнгийн байх ёстой.

Тэгэхээр би Улсын Их Хурлын гишүүний хувьд Монголын ард түмэн надад итгэдгийн хувьд энэ нүүрсний асуудлыг би толгойлж, ахалж явах саналтай байгаагаа оруулж байна. Энийгээ Улсын Их Хурлын чуулган дээр би бас санал болгож байснаа бас энд дуулгая.

Д.Ганбат: Би бас 1 үг хэлчих үү. Би Ганбаатар гишүүний саналыг бараг ойлгож байна. Энэ чинь Засгийн газар, Улсын Их Хурал. Засгийн газар бол гүйцэтгэх засаглал, Улсын Их Хурал бол хяналт тавих ёстой ард түмнийхээ өмнөөс. Тийм учраас Нямбаатар сайд дээр би эргэлзээд байх юм юу ч алга. Хуулийн дагуу Хууль зүйн сайдаа хийгээд явж байгаа ийм хүн. Харин Хууль зүйн сайдаасаа бид нар асууж тодруулах юм их гарах байх. Тэгэхээр түр хороо Нямбаатар сайд маань даргалахаар өөрөө бас танхимын зарчмаар ажилладаг, бас танхимынхаа санал бодлоос нэг их зөрөх ёсгүй гэж ойлгоод байна. Тийм учраас бас арай л

нийцмээргүй харагдаад байх юм. Олонход бас өөр санал дэвшүүлчих, нэр дэвшүүлчих хүн байна уу. Уг нь танайхаас толгойлбол би зүгээр юм гэж бодож байна. Нэр дэвшигчийг хаах гээд байна л даа. Би тэгж санал болгож байна. Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Энэ нүүрсний асуудал бол өнөөдөр Монголын нийгмийн хамгийн анхаарал татсан, ер нь хариултыг хүлээсэн 1 тийш нь яг цэгцлэх ёстой 1 номерын асуудал. Тийм ч учраас Улсын Их Хурал хаврын чуулганаар энэ Хянан шалгах түр хороо байгуулаад, энэ хороо өнөөдөр хурлаа хийгээд даргаа сонгоод ер нь шуурхай ажилдаа орох гэж байна. Энэ бол бидэнд хүлээлгэж байгаа маш том итгэл. Өмнө нь нэг түр хороо байгуулагдсан. Гэхдээ энэ нөгөө зөвхөн гаальтай холбоотой асуудал болон нэлээд тийм хязгаарлагдмал байсан бол одоо энэ түр хороо нэлээд өргөн хүрээнд асуудлыг нэг мөр цэгцэлж ард иргэддээ болон ер нь нийгэмд зөв ойлголт өгөөд энд цэг тавих ийм их хариуцлагатай түр хороо гэж би ойлгож байгаа. Тэгээд энэ бол Улсын Их Хурлаас байгуулагдаж байгаа Түр хороо. Би энэ Нямбаатар сайдыг Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооныхоо гишүүний хувьд өөрөө энэ түр хороог даргалах бололцоотой болов уу гэж бас бодож байна. Хэрвээ яг саяын Ганбат дарга, Ганбаатар гишүүний хэлдгээр Хууль зүй, дотоод хэргийн сайдын хувиар Түр хороог даргалбал энэ бас биш байх. Яагаад гэвэл энэ Засгийн газрын байгуулсан түр хороо биш. Энэ бол Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан Улсын Их Хурлыг Хянан шалгах түр Хороо. Тэгэхээр өөрөө яг энэ дээр тэр Хууль зүйн сайдын хувьд мэдээж мэдээлэлд ойрхон байдаг гэдгээрээ илүү давуу боломж олдох байх. Яг Улсын Их Хурлын гишүүн бас Хууль зүйн байнгын хорооны даргаар ажиллаж байсан хүний хувьд бас боломж нь байгаа юм болов уу гэж бодож байна л даа.

Д.Ганбат: Ингээд өөр нэр дэвшүүлэх хүн байхгүй бол нэр дэвшүүлэлтийг хаах уу. Ингээд хаалаа. 2 хүн нэр дэвшсэн байна. Нямбаатар гишүүн, Сайнхүүгийн Ганбаатар гишүүн. Олонхын саналаар юм байна. Олонхын санал гэдэг чинь 50 дээр нэмэх нь 1 байх аа.

Оролцсон гишүүдийн олонх юм уу тээ. Нэр дэвшигчээ танилцуулаад тэгээд бас асуулт асууж, хариулт авдаг байлгүй дээ. Сонгохын өмнө асуулт асуусан нь дээр биз дээ. Дэг нь ямар байх яах вэ, би зохицуулчихъя. Асуулттай гишүүд байна уу. Оюунчимэг гишүүн байгаа юм байна. Жаргалмаа гишүүн байна уу. Та орж байгаа юм уу? Кнопоо дарчихгүй юу. Би дарчихъя. Энэ чинь яадаг билээ. Оюунчимэг гишүүн асууя.

М.Оюунчимэг: Би түрүүн хэлсэн. Энэ Улсын Их Хурлын даргын захирамжаар Улсын Их Хурлаас сонгож байгаа Хянан шалгах түр хороо. Тэгээд түрүүн Ганбаатар гишүүн тэр аудитын дүгнэлт, тэгээд л худал үнэн маш их мэдээллүүд явдаг учраас маш хариуцлагатай түр хороо байгаа. Тэгээд би Нямбаатар сайдаас асуух гэж байна л даа. Энэ дээр яг Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хувиар та энд ажиллах уу эсвэл Улсын Их Хурлын гишүүний хувиар энэ дээр Хянан шалгах түр хорооны хувьд ажиллах давуу боломж байгаа гээд та өөрөө энэ дээр ямар бодолтой байна гэсэн асуултыг би асуумаар байна л даа. Түрүүн яг энийг асуух гэж байсан. Асуулт биш байсан учраас саналаа хэлсэн.

Д.Ганбат: Нямбаатар гишүүн.

Х.Нямбаатар: Баярлалаа. Би асуултад товчхон хариулья. Миний бие Улсын Их Хурлын гишүүний хувиар энэ Түр хорооны гишүүнд Улсын Их Хурлын даргын гаргасан энэ шийдвэрээр энэ түр хорооны гишүүнээр томилогдсон. Тэр утгаараа бид нар Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан

энэ үндэслэл, журмын дагуу энэ хяналт шалгалтын ажлыг явуулах ийм үүрэг хүлээж байгаа. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх маань хадгалагдаж байгаа учраас би энэ хяналт шалгалтын түр хорооны гишүүн болсон нь өөрөө тийм хууль тогтоомжийн хувьд зөрчилдөөнтэй зүйл байхгүй гэж бодож байгаа.

2 дугаарт Ганбаатар гишүүн түрүүн хэлж байх шиг байна лээ. Энэ их олон жил үргэлжилсэн асуудал байгаа гээд. Миний бие Засгийн газрын гишүүнээр томилогдоод яг 3 дахь жил дээрээ ирж байна. Энэ нүүрстэй холбоотой хэрэг шалгах ажил үндсэндээ явагдаад 20 гаран сар болж байгаа. Энэ нөгөө хилээр хууль бусаар нүүрс нэвтрүүлсэн үү, үгүй юу гээд. Тэгэхээр тэр өмнөх цаг үеүдтэй холбоотой нэгтгээд энэ ажлыг хариуцаад явахад тийм хууль тогтоомжийн хувьд зөрчилдөөнтэй зүйл 1 дүгээрт байхгүй гэж хэлэхийг хүсэж байна.

2 дугаарт Түр хорооны дарга ганцаараа асуудал шийдэхгүй шүү дээ. Энэ түр хорооны зохион байгуулалтыг л удирдаж явахаас биш Та бид бүгд яг адил тэнцүү саналын эрхтэй оролцоно. Шинжээчээ сонгож томилно. Нотлох баримтуудаа шинжлэн судална. Нээлттэй хэлэлцүүлгүүдээ зохион байгуулна. Олон нийтэд энэ далд байгаа мэдээллийг ил болгож олон нийтийн хяналт доор энэ олон нийтийн хардлагатай байгаа сэрдлэгтэй байгаа зүйлийг л ил болгох гэж байгаа зүйл, асуудал яригдаж байгаа. Тэгээд намын бүлэг дээр ч гэсэн энэ асуудлыг ярьсан. Нэг талдаа гаргаад олон нийтэд энэ мэдээллүүдийг өмнө нь олон нийтэд ил болоогүй хил, гаалийн мэдээллүүд, зөрүүтэй мэдээллүүдийг бүгдийг нь ил болох шаардлагатай. Ажил хариуцаж байсан хүмүүсийг бүгдийг нь дуудаж авчирч, гэрчээр асууж, мэдээллийг нь ил тод болгох ёстой л гэдэг зүйл ярьж байгаа юм. Тэгэхээр би юу гэдэг юм Ганбаатар гишүүнээс нууж байгаад энэ

түр хорооны шийдвэр гаргах, нөлөөлөх ямар ч тийм зүйл байхгүй шүү дээ. Энэ дандаа хамтын шийдвэр гаргаж явдаг асуудал учраас энэ дээр хууль зөрчих зүйл байхгүй.

Тэгээд зарим тохиолдолд манай гишүүд нэг зүйл дээр миний нөгөө Их Хурлын гишүүний бүрэн эрх одоо болтол хадгалаатай байгаа шүү дээ. Тэгэхээр би гишүүнийхээ эрхийг бас эдэлж энэ хяналт шалгалтын ажилд оролцооор байна гэсэн санаа.

Д.Ганбат: Болчихсон юм уу. Жаргалмаа гишүүн.

Б.Жаргалмаа: Та бүхний өдрийн амгаланг айлтгая. Нүүрстэй холбоотой аливаа мэдээлэл нягтлан хянан шалгах түр хороонд өнгөрсөн удаагийн Ганболд гишүүний ахалж байсан түр хороонд оролцъё гэдэг саналаа өгсөн боловч бас гишүүдийн тоо бүрдсэн гэдэг үүднээс түр хороонд орж чадаагүй. Тэгээд энэ удаагийн түр хороод орж ажиллах гэж байна. Тэгээд яагаад энэ түр хороод орох гээд байгаа юм бэ гэвэл олон нийтэд мэдээллийг нээлттэй болгооч ээ л гэдэг ийм саналаар түр хорооны гишүүнээр орох саналаа өгсөн. Нөгөөтээгүүр сая Нямбаатар сайд бас ерөнхийдөө хариулчихлаа л даа миний асуултад. 20 сарын хугацаанд нүүрстэй холбоотой асуудлыг хянан шалгаж, судалж байна гээд. Үнэхээр Ганболд гишүүний ахалж байсан түр хороо нээлттэй сонсголоо хийж чадаагүйгээс шалтгаалан олон нийтийн хардлага сэрдлэг улам бүр нэмэгдсэн гэж хэлж болно. Маш олон томоохон компаниуд, аж ахуйн нэгжүүд, магадгүй улс төрчид оролцсон гэх тодотголтой нүүрсний энэ асуудлаар олон нийт маш их нээлттэй мэдээллийг хүсэж байгаа. Энэ мэдээлэл нээлттэй болсноор Монгол Улсын эдийн засагт нүүрсний экспортоор оруулж ирэх, орлого улам бүр нэмэгдэх гэсэн хүлээлт байгаа. Хэдийгээр бас Хөрөнгийн биржээрээ бид нар нүүрсээ худалдаалснаар тодорхой хэмжээнд

орлого нэмэгдсэн гэж байгаа боловч улам бүр нээлттэй болох, улам бүр нүүрсний гэх асуудлын цаана байгаа авлига, хээл хахуулийн асуудлыг улам бүр илчилж нээлттэй болгож илрүүлснээр, бид хянаж чадсанаараа бас Монгол Улсын эдийн засагт томоохон үр дүнг авчирна гэж бид харж байгаа. Үнэхээр нүүрс гэдэг бол Монгол Улсын эдийн засгийн талаас илүү хувийг бүрдүүлж байгаагийн хувьд энэ дээр бас том ажил хийгдэх ёстой. Тэр ч үүднээсээ түр хороог Их Хурал баталж байгаа.

Нямбаатар сайдын хувьд асуух зүйл нь юу вэ гэвэл үнэхээр Засгийн газрын гишүүний хувиар сая ажиллах хугацаандаа холбоотой нийт хэргийн хэчнээн хувийг нь бид нар яг шийдвэрлэж чадсан бол. Одоо бидэнд маргаашаас бас нүүрстэй холбоотой гэх асуудлын 64 хүнтэй холбоотой шүүх хурал эхлэх гэж байна гэдэг ийм мэдээлэл байгаа. Бид ер нь хэчнээн хувьд нь оролцоотой байгаа бол. Магадгүй таны Хууль зүйн сайдын хувиар харж байгаа бид ажиллах ёстой гэсэн нийт хэчнээн объект гэх юм уу, субъект юм уу байгаа гэж та харж байна вэ.

Ганбаатар гишүүн хэлж байна. Надад маш их баримт байгаа. Гаднаас ирсэн маш их мэдээлэл хавтас хавтсаараа надад байгаа. Баримттай би ярина гэж байна. Та энэ түр хорооны гишүүний хувиар энэ баримтуудыг түр хорооныхоо хуралдаан дээр дэлгээд нээлттэй ажиллана биз дээ гэдэг амыг нь асууя.

Д.Ганбат: Амыг чинь асууж байх шиг байна.

Х.Нямбаатар: Би Жаргалмаа гишүүний асуултад хариулъя. Үгүй ээ, яах вэ мөрдөн шалгах ажиллагаа Хууль зүй, дотоод хэргийн сайдын үйл ажиллагаа 2 2 тусдаа зүйл л дээ. Бид нар ингээд нөгөө хуучин системийн үед ч юм уу, эс үгүй бол өөр бусад улс орнуудад жишээлбэл АНУ-д бол АНУ-ын тэр Ерөнхий

прокурорынхоо чиг үүргийг гүйцэтгээд явдаг ийм тогтолцоотой. Манай тогтолцооны хувьд бол нэг ялгаатай зүйл нь юу байдаг вэ гэвэл мөрдөн шалгах ажиллагааг зөвхөн мөрдөн шалгах чиг үүрэг бүхий байгууллагууд л явуулдаг. Хууль зүй, дотоод хэргийн яамны өөрийнх нь үндсэн чиг үүрэг бол хууль зүйн бодлого тодорхойлж, Засгийн газрын тэр хууль зүйн бодлогыг тодорхойлно. Нөгөө талдаа бүтэц тогтолцоог боловсронгуй болгох. Энэ чиглэл рүүгээ илүүтэй ажилладаг. Зүгээр мэдээж хэрэг Хууль зүй, дотоод хэргийн сайдын хувьд энэ нүүрсний хэрэгтэй холбоотой мэдээллүүд, хуулийн хүрээнд боломжтой мэдээллүүдийг авч байгаа юу гэвэл авч байгаа. Сүүлд бараг 60-аад оролцогчтой хэргийг шүүхэд шилжүүлсэн. Цаана нь жижиг Таван толгойтой холбоотой бас олон оролцогчтой хэргийн мөрдөн шалгах ажиллагаа дуусах шатдаа ороод явж байгаа гэдэг ийм зүйлийг ярьсан. Олон нийтэд ер нь бид нар би мөрдөх байгууллагын удирдлагуудтай бас яг энэ нөгөө нүүрсний сонсголын асуудал ярьж байх үед уулзаж бас санал солилцсон юм. Тэгээд бид нар ихэнх тохиолдолд ингээд нөгөө олон нийтээс мэдээллийг нууцалдаг. Энэ нь нөгөө мөрдөн шалгах ажиллагааны нууц материал гэдэг агуулгаар нууцалдаг. Одоо нэгэнт хэргийн бодит үнэнийг илрүүлж илчлэхэд саад тотгор учруулахааргүй ийм мэдээллүүд байвал та хэд маань ингээд ил болгож, бидэнд танилцуулах ийм боломж байна уу гэсэн прокурортой энэ асуудлыг ярьж гэсэн юм. Тэгэхээр манай өнөөдрийн энэ цаашид явагдах гэж байгаа түр хорооны маань ажлын нэгээхэн хэсэг энэ мөрдөн шалгалтын явцад олж авсан саяын Ганбаатар гишүүний хэлж байгаа, хардаж байгаа улс төрчидтэй холбоотой, санхүүжилттэй холбоотой ийм асуудлуудыг бид нар бас олон нийтэд ил болгож гаргаж тавья гэдэг ийм зүйл 1 дүгээрт байгаа.

2 дугаарт чи ер нь яагаад энэ түр хороог ахлах гээд сонирхолтой байна вэ гэхээр энэ түр хорооны тогтоолыг чинь Ганбаатар гишүүн ээ, би санаачлаад та хэдээр гарын үсэг зуруулаад, Их Хурлаар тогтоол болгож гаргаж ирсэн шүү дээ. Тэгэхээр би өөрөө санаачилсан хүний хувьд бас энэ Түр хороо хяналт шалгалтыг явуулахад бас бодсон зүйлүүд байна. Ялангуяа цаашид бид нар энэ хил, гаалийн мэдээ яг нэг дор л мөргөдөг л болмоор байгаа юм.

2 дугаарт сая Ганбаатар гишүүн маш чухал санаа хөндлөө. Энэ ТӨК-удыг бид нар зах зээлийнх нь зарчмаар явуулалгүй улс төрийн шийдвэрүүд ихэвчлэн гаргадаг. Дэд бүтцийн маш олон төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэлцсэнээс шалтгаалж өнөөдөр Эрдэнэс тавантолгой гэдэг компани маань зах зээлийнхээ жамаар илүү хурдан хөгжих боломж байсан. Маш олон төсөл хөтөлбөр төмөр замын олон төсөл хөтөлбөрүүд рүү шууд зах зээлийнх нь бус жамаар энэ үйл ажиллагааг орлогыг нь тийшээ төвлөрүүлээд, бүтээгдэхүүнүүдийг нь оффтейкээр явуулаад байгаа нь алдаатай байна. Тэгэхээр бид нар эцэстээ энэ хаврын чуулганы намрын чуулганы үндсэн трэнд шийдвэрүүд юу гэж гарах вэ гэхээр төрийн болон орон нутгийн өмчит компаниа хэдүүлээ засаглалынх нь хувьд сайжруулъя. Заримыг нь хувьчилъя. Төр бүх юм хийхээ больё. Нөгөө манай яамнаас боловсруулаад энэ намрын чуулганаар хэлэлцүүлэх гэж байгаа Төрийн болон орон нутгийн өмчит компанийнхаа хуулийг эцэслэе. Энэ хууль эцэслэхэд энэ түр хорооны сонсголууд их үр дүнтэй, олон нийтэд ойлгогдохуйц байна. Ер нь оймс, гутал оёхоос авхуулаад д л хоол.../минут дуусав/

Д.Ганбат: Цаг нэмж авах юм уу. Болчихсон юм уу Жаргалмаа гишүүн ээ. Би асуулт асууя. Дараа нь таных явна шүү дээ. Нэгмөсөн явчих. Ингээд зарчим алдагдах гээд байна л гэж би үзэх гээд

байгаа юм. Нөгөө гүйцэтгэх засаглал маань хуулийг биелүүлж гүйцэтгэдэг. Улсын Их Хурал маань ард түмний элч, төлөөлөгч. Бид бүхэн энэ гүйцэтгэх засаглалд хяналт тавих ёстой л доо. Тэгээд сүүлийн үед сөрөг хүчин байхгүй байна гээд бараг 3 жил ярилаа. Энэтэй л холбоотой юм байгаа юм л даа. Өмнөх түр хороонд ороод ажиллаж байсан. Ажиллах боломж ч өгдөггүй юм билээ. Уг нь энэ түр хороог цөөнх л толгойлдог л доо. Сөрөг хүчин л. Тэгээд иймэрхүү маягаар ингээд батлаад явчихсан байгаа. Тэгэхээр сайд хүн бас энэ түр хороог толгойлж болохгүй ээ л гэж үзэж байна. Угаасаа өөрийнх нь хийх ажил нь тодорхой байгаа шүү дээ. Тэр цагдаа, АТГ энэ тэрээ ажиллуулаад, тэрний дагуу хэргийг илрүүлээд, арга хэмжээгээ аваад явж байх ёстой. Тэгээд 4, 5 жил энэ нүүрсний хэрэг чинь ингээд явчихсан байна. Өнөөдрийн энэ нүүрсний түр хорооны хурал энэ бүх юм чинь нийгмийн шахалт дотор л явж байгаа байхгүй юу. Тэгэхгүй бол энийг ярихгүй, хэлэхгүй байна. Би түрүүн цухас дурдлаа. Тэр Хөгжлийн банкны асуудлыг бид бүхэн ярьсан. Юу билээ. Цуутай хүүхэн, дуутай тэнгэр шиг л сүржигнээд л тэгээд л өнгөрсөн. Цөөнхийн төлөөллөөр юм хэлүүлж яриулдаггүй л юм билээ. Тэгээд үр дүн нь ямар болсныг та бүхэн мэдэж байгаа. Тэгээд энэ муу муухай юм чинь цаанаа ингээд бөөгнөрөөд байгаа шүү. Тэгэхээр Нямбаатар сайд та нэрээ татчихвал яасан юм бэ л гэсэн ийм юм ярьж байна. Та тэртээ тэргүй зарчим ойлгодог. Олон ч түр хороо биш ээ, ажлын хэсэг толгойлж ажиллаж байгаа байх. Засгийн газартаа хамгийн чадварлаг сайдын нэг юм шиг байгаа юм. Тэгэхээр бас энэ зарчмыг хамгийн сайнаар мэдэж байгаа гэж ойлгож байна. Тэгэхээр таны ажил үүрэг давхардана.

Тэгээд бас энэ түр хороо маань яг ард түмний хүсэн хүлээж байгаа тийм хүлээлтэд хүрч ажиллахгүй ээ. Таны үүрэг чинь хоёрдмол. Хэрэв энд ингээд даргалаад ажиллавал гэсэн ийм

бодолтой байна. Та юу гэж бодож байна.

Х.Нямбаатар: Ганболд гишүүний ахалсан түр хороо чинь хугацаа нь дуусчихсан шүү дээ. Тэгээд та их санаа зовож байсан юм бол Ганбат дарга та дахиад түр хорооны тогтоол тухайн үед санаачлахгүй яасан юм бэ. Би санаа зовоод санаачилсан юм.

2 дугаарт та миний Улсын Их Хурлын бүрэн эрхэд халдахгүй, халдах эрх байхгүй. Улсын Их Хурлын гишүүний, би өөрийнхөө бүрэн эрхийн хүрээнд энэ тогтоолын төслийг санаачилж Их Хурлаар батлуулсан.

2 дугаарт энэ нүүрсний болон ер нь ТӨК-уудтай холбоотой асуудлыг та бүхэн танай нам сөрөг хүчин ярьж эхлээгүй Монгол Улсын Засгийн газар өөрөө шалгалт оруулж, гүйцэтгэх удирдлагуудыг нь чөлөөлж, БЭТ тавьж, эрүүгийн хэрэг үүсгэх тэр хяналт шалгалтын материалуудыг хууль хяналтын байгууллагуудад хүргүүлсэн юм аа. Та дахиад параллелийн тогтоолын төсөл санаачлаад, зэрэгцүүлээд ахлаад явах боломжууд байгаа. Тэгэхээр та тэр эрхээ эдэл ээ. Би өөрөө санаачилсан тогтоолынхоо энэ түр хороог өөрөө ахлаад явъя. Энэ 1 хүн шийддэггүй олон нийтэд бид нар ил болгож энэ мэдээллүүдийг тавьж, Улсын Их Хурлын хяналт шалгалтыг хэрэгжүүлж гэдэг ийм агуулга бүхий Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулийг бид нар бас батлуулж байсан. Тэгэхээр энэ параллель явж болно. Та миний шударга бус ажиллахад ихэд эргэлзээд байгаа бол та дахиад зэрэгцүүлээд өөр хяналтын түр хороо байгуулаад, өөрөө ажиллаж болно.

Тэгээд дандаа нөгөө юуны хойноос билээ? Ниргэсэн хойно нь хаихирав гэдэг ийм зүйл битгий ярьж бай гэдгийг би танд их л олон удаа хэлж байгаа даа.

Д.Ганбат: Яах вэ би яг л адилхан нөгөө асуусан. Нэмэлт 1 минут аваад дахиад тодруулчихъя.

Үгүй ээ, би зарчим л яриад байгаа юм л даа. Тэгээд нөгөө л 3 жил ямар байсан яг түүгээрээ л ингээд явах гээд байх юм. Зарчим чинь ийм байдаг шүү. Тэгэхээр чинь болохгүй юм биш үү. Энэ чинь нөгөө 3 засаглал байгаа шүү дээ. Би таны эрхийг хасаж барьж байгаа юм ерөөсөө байхгүй ээ. Уг нь ийм байдаг юм. Тэгээд таны ажил үүрэг чинь давхардаад байна. Та маш их олон ажил хариуцаж байгаа. Гэмт хэрэгтэйгээ тэмцэх гээд. Танайханд хэлээ шүү дээ. Олонх бас өөр хүн санал болгож болохгүй юу гээд. Тэгээд энэ чинь олон нийтийн мэдэх эрх гэж байна шүү дээ. Олон түмний. Энэ чинь улсын, ард түмний татвар төлөгчдийн мөнгө чинь л урсаад байгаа шүү дээ цаана нь. Тэгээд 3 жил сайд хийчихсэн хүн. Тэр хооронд баахан нүүрсний хулгай гарчихсан байхад, би тогтоолын төсөл санаачилсан, энийгээ би дуустал нь явна энэ тэр гээд ингээд энэ чинь бас нэг ээлжит шоу болох гээд байна л гэж хэлж байна шүү дээ.

Тэгээд удаа дараа анхааруулсан, тэгсэн, ингэсэн гээд иймэрхүү заналхийлсэн юм яриад байх юм. Би энэ хурлыг удирдаж байгаа болохоор ингээд чөлөөтэй асуугаад хариулуулаад болж байгаа байхгүй юу. Ингэж байж л энэ чинь улс орон чинь цаашаа хөгжинө, явна. Энэ ард түмэн чинь мэдэх эрхээ эдэлнэ шүү дээ. Тэгэхгүй ингээд л цаана нь ингээд л бөөгнөрүүлээд л, цаана нь ингээд л хорт хавдар, идээ буглаа энэ юмыг чинь ингээд л байгаад байхаар чинь иргэд чинь улам л бухимдаад байна шүү дээ. Улсын Их Хурал ажлаа хийж чадахгүй байна гэж дүгнээд байна. Тэгээд Засгийн газар 1 их сүрхий ажил хийдэг юм шиг. Засгийн газрынхаа ажлыг хийж чадахгүй байж байж тийм л сайн сайхан байсан бол өнөөдөр Монгол Улс цэнгэлийн манлайд хүрчихнэ яасан юм. Ямар байгаа билээ. Засгийн газар л гоё байгаа гээд байх юм. Тэгээд ард

түмнийхээ амьдралыг очоод л хар л даа. Би тойргоороо явж байгаад л ирлээ. Тантай санал нийлэхгүй байна. Та хариулах юм уу. Дараагийн хүн нь асуугаад явчих уу. Би бол та гэж яриад байгаа шүү.

Ганбаатар гишүүнээс асуух хүн байна уу. Сүхбаатар гишүүн.

Ж.Сүхбаатар: Энэ хянан шалгах түр хороо байгуулах тухай асуудал байж байна. Энэ асуудал нь бол их онцлогтой ийм асуудал байж байгаа. Нүүрсний хэрэг явдал буюу нүүрс тойрсон ийм асуудал манай улс орны иргэдийн санаа бодлыг зовоосон ийм асуудал байна. Зарим нь хэлж байна шүү дээ. Энэ мафийн шинжтэй үйл ажиллагаа. Олон жилийн бас ажилтай, олон жилийн ийм үйлдэлтэй ч холбоотой байж магадгүй. Энд аль нэгэн нам засгийг холбож ярих боломжгүй. Нүүрстэй холбоотой асуудал дээр явж байгаа Улсын Их Хурал, Засгийн газрын явуулж байгаа үйл ажиллагааг харах юм бол та бүхэн мэдэж байгаа. Энэ асуудалд намчирхаад хандах юм байхгүй байгаад байгаа. Тухайлан ярих юм бол эрх баригч нам өөрөө энэтэй холбоотой байгаа бас хэд хэдэн гишүүдийнхээ асуудалд хатуу хандаж байгаа шүү дээ. Өмгөөлсөн, хамгаалсан байр суурь хийхгүй байгаа. Энэ бол иргэдийн төрд итгэх итгэлийг бэхжүүлэхтэй холбоотой, хууль ёсыг мөрдүүлэхтэй холбоотой. Тэгэхээр би энэ Ганбат гишүүний санал, дүгнэлтийг хүндэтгэн үзэж байгаа ч гэсэн Нямбаатар сайдын хувьд онцлогтой байгаа. Бид нар ингээд яг тодорхой далд шинжтэй удаан үргэлжилсэн олон удаагийн янз бүрийн үйлдэлд олон оролцогчтой энэ асуудал дээр томоохон тэмцэл хийж байна. Тэр тусмаа бүүр онцолж хэлэх юм бол эрх баригч нам өөрөө дотооддоо ч, гадна талдаа ч. Тэгээд яг энэ тэмцлийг толгойлж байгаа, манлайлж байгаа хүн нь анхнаасаа Нямбаатар гишүүн анх л тэмцэж байсан. Тэр шударга ёсны тэмцэл чинь хоосон байгаагүй л байгаа. Энэ олон

ажлууд явагдаж байна шүү. Шувуу ажиллагаа авлигатай хийх тэмцэл. Үүний том тэмцэл нь нүүрсний асуудал байгаа юм. Их Хурал дээр ямар нэгэн байдлаар түрүүний таны хэлээд байгаа шиг саармагжих ёсгүй байгаа. Улс төрийн өнгө аясаар. Угаасаа Нямбаатар сайд энэ дээр би намчирхсан улс төрийн өнгө аясаар биш, тухайн этгээдүүд рүү бол ажиллагаа явуулж байгаа. Гэхдээ хамгийн том саармагжилт гэдэг юм уу янз бүрийн асуудлууд Их Хуралд үүсэж парламентад үүсэж болзошгүй гэдэг ийм яриа өөрөө үл итгэсэн байдал их байгаад байгаа шүү дээ. Тийм учраас түр хороог ингээд Ганбаатар гээд манай олон жил тэмцэж асуудалд шударга хандаж байсан хүн оруулж байна. Ганбат гишүүн гээд өөрөө хамгийн зарчимч байр суурь дээр бас тодорхой бас зарим үед бол маш хүчтэй байж чаддагийг хэлж байна. Гэхдээ нэгийг нөгөөгөөрөө. Хөгжлийн банкны сонсгол таны дүгнэлтээс үл хамаараад түүхэнд орно. Ард түмний өмнө үүргээ гүйцэтгэсэн, илчилсэн үү илчилсэн. Тэндээс хэн нэгэн хүн ял оноосон юм байхгүй. Бүгд дүгнэлт хийсэн шүү дээ. Эрх баригчид нь ч дүгнэлт хийсэн. Сөрөг хүчин нь ч дүгнэлтээ хийсэн. Иргэд нь ч дүгнэлтээ хийсэн. Бизнесийнхэн ч дүгнэлтээ хийсэн. Маш том сургамжийг үлдээсэн шүү дээ. Тэгэхээр энэ тухай асуудлыг үгүйсгэх замаар юмыг явуулж болохгүй. Энэ шинэ анхны эхлэл байлаа. Та тэрэнд идэвхтэй, идэвхгүй оролцоод, сэтгэл дундуур үлдсэн нь бол протоколд тусдаа ингээд үлдэх нь үлдэнэ.

Гэхдээ би нэг зүйлийг эргэлзэхгүй. Хэдэн жилийн дараа таны наад дүгнэлт биш бид нарын хийсэн ажил бол ишлэгдээд та ч бараг ишлээд явж ирж магадгүй. Хуралдаан элдэв юм дээр үгүйсгэж байгаа зүйлээ. Ерөөсөө барьж авах юм нь тэр болчихсон шүү дээ. Урьд нь барьж авах юм байгаагүй байхгүй юу. Тэгэхээр одоо ингээд ярьж байгаа юм дээр санал бодлоо хэлээд, олонх цөөнхийн зарчмаараа гээд ер нь бол аливаа юм дээр бас онцгой нэг удаагийн тохиолдол гэж

байдаг. Би бол энэ дээр та бид нарын хэн ч болж болох ч гэсэн илүү энэ асуудал дээр олон жил тууштай яваад өөрөө бас улс төрийн олон эрсдэл, заналхийлэл гэдэг юм уу болзошгүй энэ дунд Нямбаатар сайд яваад өөрийгөө бас харуулаад байгаа юм. Энэ хүнийг бас цаана нь ойлгох хэрэгтэй. Энэ хүн чинь юмны ард нэг гарчихъя. Их хурал, Засгийн газар дээрээ дэмжлэгээ олон нийтдээ аваад явчихъя. Хэн нэгэн хүний нөлөөнд энэ хүмүүсийг оруулахгүй аваад явъя. Тийм учраас Ганбат гишүүн, Ганбаатар гишүүн та бид, Цогтгэрэл гээд бид хэдийн оролцоо л явна. Тэгээд энэ далд явагдахгүй. Сонсголын хэлбэр ил явагдана. Тэгэхээр энэ дээр бол аль аль талаасаа.../минут дуусав/

Д.Ганбат: Яах вэ нэг минут авах уу. 1 минут.

Ж.Сүхбаатар: Тэгэхээр нөхцөл байдлаа харах юм бол би шулуухан л хэлье. Өнөөдөр энэ дотор байгаа гишүүд дотроос хамгийн олон талын хууль зүйн хувьд, улс төрийн талаасаа, нийгмийн талаасаа бол итгэлийг илүү хүчтэйгээр хүлээгээд тууштай тэмцэл хийгээд, үр дүн гаргаж чадах хүн нь бол өнөөдөр Нямбаатар л байна л даа. Яах вэ та бид өөрсдөө мундаг л хүмүүс байх. Гэхдээ өнөөдөр мундаг нь биш, боломжит үр дүн гаргаад яг зөв тэр голоороо явчих тэр зүйлд нь бол бид анхаарлаа хандуулах ёстой. Тэгээд Нямбаатар сайдад ч гэсэн гишүүнд хяналт тавиад явж чадна шүү дээ бид нар. Энэ чинь нэг хүн шийдэх гэж байгаа биш. Түрүүн та хэлж байна. Тэмцлийн утга учир гэж бас байгаа. Тэмцэл гэдэг бол зүгээр нэг тийм янз бүрийн шоу биш. Үр дүнгээр л хэмжигддэг. Бас талаар өнгөрөөгүй. Тэгэхээр бид энд бол бүгд нүүрсний хэрэг явдал дээр хатуу байр суурьтай байгаа хүмүүс энд орж ирсэн гэж.../минут дуусав/

Д.Ганбат: Цогтгэрэл гишүүн. Та байж байх уу. Жаргалмаа гишүүний асуултад Ганбаатар гишүүн хариулчих

уу. Ганбаатар гишүүн. Хоёулангаас нь асууж байх шиг байсан.

С.Ганбаатар: Ганбаатар гишүүнд зөндөө олон мэдээлэл байгаа тэрийгээ ер нь дэлгэнэ биз дээ гэж ам асууж байна. Амаа өгье өө. Аль хэзээний дэлгэсэн. Аль хэзээний би лайв хийгээд, миний фэйсбүүк пэйж дээр 27 асуудлаар ард түмэндээ хандчихсан. Би яг 2 асуудлыг л дэлгэж чадахгүй байгаа. Тэр нь юу вэ гэвэл нууцын шатад байгаа 2 гэрээ байгаа. 2 гэрээ байгаа. Яг 2 гэрээ бол нууцаас гараагүй байгаа. Тэр 2-ыг би гаргаж чадаагүй. Чадахгүй. Тэр дотор нууцлаад байх юм юу ч байхгүй. Зүгээр л Монголчуудаас хулгайгаа нуусан л асуудал. Даанч олон улсын гэрээ учраас би бас хэм хэмжээгээ зөрчиж чадахгүй учраас тэрийг дэлгээгүй. Бусдыг нь би пэйжээрээ бүгдийг нь дэлгэсэн байгаа. Энэ асуудалтай холбогдуулаад энэ материалуудаа бүгдийг нь өгнө. Энэ дээр чинь бараг 2 портер дүүрэн хайрцагтай материалуудыг бид бүтэн 5, 6 сар үзэж байгаа юм шүү дээ. 8 удаа бид хуралдсан. Бүр ингээд 5 шинжээчид их сайн ажилласан. Тэр ажлын албаныхан ч гэсэн их сайн ажилласан. Тэгэхээр тэр хөдөлмөр бол бүгд дээр нь дэлгэгдэнэ мэдээж. Зүгээр миний хэлж байгаа зүйл гэвэл энэ хариуцлага. Тэгээд би нэг их дарга, цэрэг болъё гэж ерөөсөө хүсдэггүй. Сайд, дарга, цэрэг болох боломжууд байсан л байх. Зүгээр тийм юм бол үнэндээ моодноос гарчихсан шүү дээ. Бөөлжис цутгамаар. Зүгээр харин би хариуцлага үүрье. Фридрих Эбертийн сангаас Улсын Их Хурлын хяналтын тухай хууль анх Эбертийн сангаас бас саналууд нь орж ирж байсан. Яг энэ хуулийн төслийн одоо чинь энэ Улсын Их Хурлын хяналтыг хүчтэй байлгая гэдэг тухай хуулийн дээр бид хуулийн нэг хэрэгжилт шүү дээ энэ хяналтын хороо гэдэг. Тэр дээр анх орж ирсэн хувилбар нь Германы шинжээчдээс бид санал авч байсан. Тэгэхэд бол сөрөг хүчин нь энэ хяналтын хороогоо удирдана шүү гэсэн тийм утга санаа, үг, өгүүлбэр их явж байсан. Тэгээд одоо яах вэ тэрийг

манайхан зүгээр сөрөг хүчнээс төлөөд л оролцуулна гээд л бөөрөнхийлөөд л мохоо болгоод л хаячихсан л даа. Ер нь бол утга санаа нь сөрөг хүчин нь эрх барьж байгаа, мөнгө мэдэж байгаа, мөнгө шийдэж байгаа, мөнгө идэх магадлалтай хүмүүсээ хар сэргүй хянаарай л гэсэн утга санаагаар би хэлж байгаа.

Надтай нэр дэвшиж байгаа хүнийг би хувь хүний хувьд ерөөсөө ярьсангүй. Зүгээр л би зарчим ярьж байна. Тэгэхээр би Их Хурлын индэр дээрээс хэлж байсан санаагаа би хэлж байгаа юм. Тэгээд энэ ард түмний өмнө том хариуцлага үүрч байгаа юм. Би хариуцлага авъя л гэж байгаа юм. Дээр нь энэ аймшигтай том хулгай цаашид гарахгүй байх эрх зүйн орчныг бүрдүүлж, хулгайг таслан зогсооё.

2 дугаарт тэр бий болсон хор хохирол, нөлөөг хохирлыг нөхөн төлүүлэе. Ингээд л 2 хүн шоронд хийгээд л, тэгээд л чимээгүй нам дарж болохгүй шүү дээ. Алсын хараа 2050 гэдгийг чинь би ерөөсөө ойлгохгүй байсан чинь одоогоос ойлгоод эхэлж байгаа шүү дээ. Хорьчихоод л тавиад байх юм биш биз дээ л гэдэг санаагаар би ярьж байгаа. Таслан зогсоох, хохирлыг нөхөн төлүүлэх.

3-д нь миний хүсэж байгаа зүйл. Жижиг хувьцаа эзэмшигч 1072 хувьцааг үнэнээсээ хувьцаа болгоё. Би энийг энэ аудитын материал дээр бас сайн юм гарсан байна лээ шүү 3.3-д. Иймд жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах нь компанийн нэр хүнд өсөх, хөрөнгө оруулалт татах нөхцөл бүрдэх, хяналт сайжрах зэргээр сайн засаглал бий болох боломжтой тул Эрдэнэс Тавантолгой ХК-ийг нээлттэй ХК болгох замаар хөрөнгийн зах зээлийн ингээд үр нөлөөг бүрдүүлнэ гэсэн ийм том өгүүлбэр байна. Энэ олон шийдлээ хүлээсэн ажлууд байж байгаа. Тэгээд энэ ажлын хэсэг дээрээ би энэ саналуудаа тавиад явна. 100 мянган хүний санал аваад эхэлчихсэн байгаа. Гарын үсэг цуглуулаад.../минут дуусав/.

Д.Ганбат: 1 минут авах уу. Болчихсон юм уу. Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Энэ нүүрсний хулгай гэж нэрлэгдээд байгаа асуудал бол үнэхээр бас эдийн засгийн тоо хэмжээгээрээ ч гэсэн иргэд, олон нийтийн бухимдлыг төрүүлж байгаа тэр шударга ёс, хууль ёсыг нэхэж байгаа талаасаа ч гэсэн тэр үнэхээр бас чухал асуудал. Тэгэхээр өмнө нь бас яг ийм нээлттэй сонсгол болж байсан. Энэ дээр яг энэ цаасан дээр бичсэнээр энэ сонсголын 1 том зорилго бол иргэд, олон нийтийг мэдээллээр хангах ийм зорилготой. Иргэд, олон нийтийг ард түмнийг мэдээллээр хангах. Тэгээд өмнөх Хөгжлийн банкны сонсголын үеэр манай бүлгээс орсон гишүүдийн зүгээс ярьж байсан яриа бол ийм мэдээллийн ялгаатай байдал бий болчихдог. Яг одоо орж байгаа дарга, цэрэг олон хүмүүсээсээ хамаараад маш их ялгаатай мэдээлэлтэй гишүүд сонсгол дээр ороод, ажлын хэсгийн гишүүдийг явцын дунд мэдээллээр ялгаатай хангаснаас болоод бид нар ороод яг тэр дээр бол үнэхээр тэр чинь эцсийн эцэст иргэд олон нийтийг мэдээллээр хангах зорилготой энэ сонсгол чинь мэдээлэл дээр л тулгуурлагдаж явагдана шүү дээ. Энэ мэдээлэл чинь өөрөө илүү анхнаасаа тэгш өгөгдөж явах ёстой. Тэгэхээр аль нэг нь дарга болох хүмүүсийг энэ дээр л илүү асуухаар нэг жижүүрийн хариулт мэдээж хэлчихнэ. Энэ дээр л анхнаасаа зөв зүйтэй ажиллаасай, ёс зүйтэй ажиллаасай, гишүүдийг адилхан мэдээллээр хангаасай. Энэ чинь эргээд энэ улс олон нийтэд ард түмнийг мэдээллээр хангах үүргийг биелүүлэх бололцоог нь олгоосой, энэ дээр жинхэнээсээ энэ дээрээсээ ёс зүйтэй хандаж байж асуудал бас цаашаагаа явна шүү гэдгийг л бас нэмж хэлэх гэсэн юм.

2 дугаарт нь тэр ер нь цааш цаашидаа зарчмаараа болдог бол энэ аливаа сонсголыг сөрөг хүчнээс л авч явах

ийм л шаардлага, энэ өөрөө бас яг зүй ёсны хувьд ийм шаардлага бас тавигдаж байна л даа. Хэдийгээр эрх баригчдын нүүрсний асуудлыг сөхөж тавиад явж байгаа гэж хэлдэг ч гэсэн энэ чинь зөвхөн ноднин уржсан гарсан асуудал биш дээ. Яг энэ эрх баригчид чинь 2 дахь парламентын хугацаанд 7, 8 дахь жилдээ засаглаж байна шүү дээ. Энэ эрх баригчдын хий үед хийсэн энэ хүмүүсийн томилгоо олон зүйлээс л гарсан л асуудал шүү дээ. Энэ багийн л бүтээл шүү дээ эцэст нь.

2 парламент дамжаад явж байгаа багийн уран бүтээлийн тоглолтууд л энд явж байгаа шүү дээ. Дахиад тэгэнгүүтээ өөрснөө ахлаад явна гэдэг чинь дахиад нөгөө мэдээллийг удирдаж, мэдээллийн ялгаатай байдал дээр тоглож эхлэхээр дахиад яг юу болох билээ. Тэгэхээр энэ зарчмуудаа бариад бас уг нь бол тэр цөөнхийн төлөөлөл нэр дэвшиж байгаа хүнээр нь ер нь цааши цаашидаа энэ аливаа сонсгол дээр явах энэ нь бол өөрөө бас энэ парламентад ёсны өөрийнх нь нэг зүй ёсны шаардлага болж тулгарч байна л даа. Би тэдгээрийг л хэлэх гэсэн юм. Надад бол асуулт алга. Өнөөдөр нөгөө чуулганы завсарлагааны үе болохоор бас гишүүд цуварч ирж байх шиг байна. Энх-Амгалан гишүүн.

Б.Энх-Амгалан: Би энэ Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороо байгуулагдаж, даргаа сонгох гэж байгаад баяртай байгаа юм. Энэ төрийн болон орон нутгийн өмчтэй энэ компаниудын тэр нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, худалдан авалт, ажил үйлчилгээ тэгээд энэ хяналт шалгалттай холбоотой асуудлаар олон нийтэд мэдээллээр хангах мэдээллүүдийг шинжлэн судлах ийм зорилготой байгуулагдаж байгаа ийм түр хороо. Тэгээд хэн ч дарга нь болдог бай. Би зүгээр түр хорооны гишүүдэд 3 зүйлийг л анхааруулах гэсэн юм.

Нэг дэх нь хулгайч л бол хамгийн түрүүнд хулгайчтай тэмцээрэй гэж

хаширдаг. Тийм учраас жинхэнэ хулгайчийг нь олгоорой л гэж хэлэх гэж байгаа юм. Анх бид нар 2016 онд орж ирж байхад бол 360 мянган тонн нүүрс алга болчихсон гээд Их Хурлаас Нямбаатар сайд Оюун-Эрдэнэ гишүүн бид нар бөөнөөрөө явж очиж үзэж байхад үнэхээр толгой алга болчихсон байсан. Тэр үед энэ толгой яасан юм гэсэн шатчихсан гэж авч байсан шүү дээ өмнөөс. Шатчихсан гэж. Тэгээд тэр хувийн орон нутгийн өмчит 5 толгой болоод тэр том 5 толгой жижиж 5 толгой 2-ын хооронд тэр нүүрсээ зөөдөг, хийдэг, барьдаг ийм нарийн юмнаасаа юм чинь эхэлсэн юм байна лээ шүү. Тэгээд энэ 360 мянган тонн нүүрс гэдэг бол хүрз нүүрс биш, портер нүүрс биш шүү дээ. Тэгээд Монгол Улсын хилээр машин засах гэж байгаа, орох гэж байгаа гэдэг 9 шидийн мэдүүлгээр гарсан маш том сүлжээ байгаа юм. Энэ сүлжээний талаар өнөөдөр хэн ч, юу ч ярихгүй байгаа юм. Тэгсэн хэр нь хэдэн Их Хурлынхаа гишүүдийг барьж авч ноолоод, анхнаас нь олон түмэнд гаргаж ирэхдээ энэ хулгайч юм байгаа юм гэж зарлаад, тэрнийх нь араас хэвлэл мэдээллийнхэн баахан энэ хулгайч зэлгээчийг алаад өг, дүүжлээд өг гэж баахан юм яваад, тэрнийх нь араас хууль хяналтын байгууллагууд нь гарч ирж хэвлэлийн бага хурал хийгээд., энэ юм ингээд юу ч биш болоод замхарсан. Тэгэхээр зэрэг энэ том хулгай наанаа зүгээр сүр дуулиан гараад ингээд хэдэн хүний нэр цохоод тэгээд тэр нь болсон ч юм уу үгүй, болоогүй ч юм уу ингээд замхраад дуусчих вий гэж би санаа зовж байгаа юм. Тийм учраас жинхэнэ хулгайчид нь олох тал дээр анхаараарай гэж.

2 дугаарт энэ дээр хэлмэгдүүлэлт гарах вий гэж би бодож байгаа юм. Монгол Улсын Үндсэн хуулиар бол хууль шүүхийн өмнө хүн болгон тэгш эрхтэй. Шүүхээр гэм буруу нь тогтоогдоогүй байх үед хэнийг ч гэм буруутай гэж үзэж болохгүй гэдэг ийм үндсэн хуулийн заалттай. Гэтэл хууль хяналтын

байгууллагууд гарч ирж яг хэвлэлээр гарч ирээд мэдээлэл хийчихдэг. Дээр нь камерын өмнө хэрэг яриад сууж байдаг. Энэ бол шүүхэд нөлөөлөх гэсэн оролдлого. Тэгээд нийгмийн уур амьсгалыг тэр олон троллуудаараа түрүүлээд гаргахдаг. Хэрэг нь шийдэгдээгүй, яллагдагчаар татаад, тэр тогтоолтойгоо танилцаагүй байхад гарч байгаа шүү дээ мэдээлэл нь. Энэ бол ерөөсөө энийг Шүүхийн ерөнхий зөвлөл энэ асуудал дээр тодорхой мэдээлэл гаргасан. Энэ бол шүүхэд нөлөөлөх гэсэн оролдлого шүү гэж. Ийм байдлаар явах юм энэ хэлмэгдүүлэлт болно цаашидаа. Улс төрийн өшөө авалт болно. Тэгэхээр энийг та бүхэн маань энэ дээр маш сайн анхаараарай. Ялангуяа Шүүхийн ерөнхий зөвлөлтэй энэ асуудлуудыг ярьж, та нарын судалж байгаа, шинэчилж байгаа мэдээллүүд чинь түрүүлж гараад хэн нэгнийг намнаад байдаг тийм тааврын нөгөө бооцоот тоглоом шиг юм болчих вий дээ. Сонгууль дөхөж байна. Тэгээд ирэхийн алдад нэгнийгээ намнах, өрсөлдөгчөө намнах ийм юм болчих вий дээ гэж би ингэж санаа зовж байгаа юм.

3 дахь нь үнэн мөнийг нь тогтоохын тулд би та бүгдийг судалгаа сайн хийгээрэй л гэж хэлэх гээд байгаа юм. Энэ чинь бүх юм хар дээр цагаанаар байж байгаа шүү дээ. Хэдэн тонн нүүрс ямар гэрээгээр хаашаа гарчав, ямар үнээр гарчав, тэр гэрээ дээр хэн гарын үсэг зурав.

Д.Ганбат: 1 минут.

Б.Энх-Амгалан: Хэдэн тонн нүүрсийг хэн тээвэрлэв. Тээврийн гэрээг нь хэн авав. Хэдэн тонн нүүрсний ажил, үйлчилгээ, худалдан авалтыг хэн зохион байгуулав гэдэг энэ юмнууд цагаан дээр хар дээр байж байгаа. Санхүүгийн баримт дээр тулгуурлаж та бүхэн маань юмнууд үзээрэй гэж би та бүхэнд хүсэх гээд байгаа юм. Тэгэхгүй бол энэ ингээд дахиад нэг тийм дуулиан болоод өнгөрчих вий дээ. Эсвэл нөгөө жинхэнэ эзэд нь ард нь үлдээд, тэгээд жирийн нэг төрийн

албан хаагч юм уу, жирийн нэг компанийн нягтлан асуудалд орчих вий дээ гэж бодоод байгаа юм. Тэгээд та бүхэндээ амжилт хүсье.

Д.Ганбат: Санал хэлчих шиг боллоо. Асуулт байсангүй. Доржханд гишүүн.

Т.Доржханд: Баярлалаа. 2 хүн нэр дэвшиж байгаа юм байна л даа. Тэгээд асуух ёстой юм байна шүү дээ. Яах вэ, ер нь зүгээр надад тодорхой асуулт байна л даа аль алинд нь. Ялангуяа Нямбаатар сайдаас асуух юм байна л даа. Тэр нь юу вэ гэхээр ажлын хэсгийн дарга боллоо гээд өнөөдөр бид нар энэ нүүрсний хулгайн асуудлыг нээлттэй хэлэлцлээ гээд, тэгээд дараа нь нөгөө үр дүн маань яах вэ гэдэг дээр би бүүр эргэлзээд байна.

Хөгжлийн банкны нээлттэй сонсголыг бид нар их сайн хийсэн шүү дээ. Тэгээд бүх баримттай фактыг нь гаргаж ирсэн шүү дээ. Энд сууж байгаа хүмүүс хүртэл ард талдаа асуудалтай юм байна гэдэг нь нотлогдсон шүү дээ. Тэгэхэд тэгээд наадмын өмнө шүүх дээр гацааж гацааж баахан ингэж 1, 2 сар хэлэлцүүлж хэлэлцүүлж 1 том өрөөнд хорьж хорьж байгаад, тэгээд нөгөө нөхөд чинь ямар ч ял аваагүй, шийтгэл аваагүй шүү дээ. Тэгээд хэдэн жараахайнууд нь Хөгжлийн банкны хэдэн газрын захирал, хэлтсийн захирлууд нь л ял аваад л бусад нь бүгдээрээ цагаандаа гарлаа шүү дээ. Үгүй ээ, тэгвэл энэ парламентын хяналтын шаардлага юу байгаа юм. Тов тодорхой асуудлууд байсан шүү дээ. Бүгдээрээ фактаар ил гараад ирчихсэн. Баримттай, нотолгоотой. 5 сая гүйлгээ шалгаж байгаад бүгдийг нь баримтаар гаргаж ирсэн шүү дээ. Хамаарал бүхий компаниудыг нь. Тэгээд яг ийм нэг жүжиг болчих вий гэдэг дээр нэг санаа зовоод байна. Тэгээд үр дүн байхгүй хуулийн байгууллага руу өгдөг, тэгээд тэд нар нь цайруулаад хаячихдаг. Үгүй ээ, тэгээд одоо яах билээ гээд. Тэгэхээр Нямбаатар сайдаас бид нар ингээд

дахиад 6 сар ажилласан шүү дээ. Нэлээн олон баримтууд цуглачихсан байгаа. Хугацаандаа л энэ сонсголыг хийж чадаагүй болохоос биш. Дахиад энэ Хөгжлийн банкны араас орчихвол яах билээ. Зүгээр энэ парламент чинь аягүй сул өлбөгөр харагдана шүү дээ. Шийдвэр гаргадаггүй, чаддаггүй, нотолгоотой баримттай байгаад байхад чинь хүртэл түүнийг нь хэрэгждэггүй, ойшоодоггүй ийм хуулийн байгууллагатай байгаа үед яах юм бэ. Та Хууль зүйн сайдын хувьд дараа нь энэ ажлыг бас хариуцаж байгаа хүний хувьд яг үр дүнгээ яаж харж байна гэдэг ий 1 дүгээр асуулт байна.

2-т нь энэ зарчмын хувьд энэ түр хороо хяналтын байгууллагыг чинь сөрөг хүчин авч явах ёстой гэдэг дээр би бас 100 хувь саналтай байдаг. Тэгээд Хөгжлийн банк дээр ч гэсэн өөрийнхөө нэрийг дэвшүүлж байсан. Тэгээд мэдээж нэг олонхоороо тэгээд л хүч түрээд л олонхоороо л томилж байсан л даа. Гэхдээ яах вэ үр дүн гарсан. Би зарчмын хувьд энэ сөрөг хүчин л хяналтаа хийх ёстой гэдэг дээр цаашидаа энэ хуульдаа өөрчлөлт оруулах ёстой юм байна. Анхны тэр гаргаж ирсэн санал санаачилгаар явах ёстой байсан юм байжээ л гэдэг дээр хатуу итгэл үнэмшилтэй байгаа. Гэхдээ энэ сөрөг хүчин гээд Ганбаатар гишүүний нэр орж ирж байгаад би гайхаж л байна. Одоо энэ нүүрсний пирамид гэж яриад байгаа хамгийн том толгой дээр нь толгойлогчтой нь л хөтлөлцөөд яваад байгаа хүн шүү дээ. Хөдөө орон нутгаар. Үгүй ээ, тэгээд ийм улайм цайм нөлөө бүхий хүнтэй холбоо сүлбээтэй байж яаж энийг хянана гэж үзэж байгаа юм бэ. Тэр дээр та байр сууриа илэрхийлэх хэрэгтэй. Хамгийн том пирамидын толгой бол тэр хүн шүү дээ.

Оффтейк гэрээ 19 их наядын шийдвэрийг гаргасан. Ерөнхийлөгч байхдаа тэр шийдвэрүүдийг гаргасан, нууцалсан. Тэгээд сонсгол хийх болонгуут зугтаагаад явчихсан. Тэгээд энэ хүний чинь асуудал яригдана шүү дээ. Тэр үед

та яах юм. Хараат бусаар асуудалд хандаж чадах юм уу. Тийм эр зориг байна уу. Би бол эргэлзэж байна. Та энэ дээр нэг хариулт өгмөөр байна. Баярлалаа.

Д.Ганбат: Эхлээд Нямбаатар сайд хариулъя.

Х.Нямбаатар: Баярлалаа. Яах вэ, шүүхийн гаргасан шийдвэрт бид шууд коммент хийх тийм эрх хэмжээ байхгүй.

2 дугаарт Хөгжлийн банктай холбоотой асуудлыг зөвхөн анхан шатын шүүх шийдчихээд байгаа. Удахгүй давж заалдах шатын шүүх хурлаар анхан шатын шүүхийнхээ алдааг засаж залруулах ийм хуулийн хэд хэдэн боломжууд байгаа байх. Ер нь юу гэдэг юм, 18 дугаар зууны үед Шарлю Монтекагийн бичсэн “Хуулийн амин сүнс” гэдэг зохиолыг л хэдүүлээ яг тал талаас нь тойрч ярьж байна л даа. Өөрөөр хэлбэл энэ 3 засаглал, 3 эрх мэдэл, харилцан бие биедээ хяналт тавих ёстой. Тийм учраас өнөөдрийн бид нарын энэ гүйцэтгэх эрх мэдлийн, хууль тогтоох эрх мэдлийн хяналтын сонсголыг хийх гээд өнөөдөр тал талаасаа санал бодлоо уралдуулаад л ярьж байгаа юм.

Тэгэхээр олон нийтийн хяналт гэдэг энэ 3 хяналтыгаа улам илүү бэхжүүлж өгдөг хяналтын нэг хэлбэр нь бол яах аргагүй анхдагч засаглалаас үүдэлтэй. Хууль тогтоох парламентын хяналтыг л өнөөдөр бид нар хийх тухай асуудал яригдаж байгаа. Ер нь зүгээр би Доржханд гишүүнтэй нэг зүйл дээр маш их санал нийлдэг гэж өөрийгөө боддог. Тэр юу вэ гэвэл энэ төрийн болон орон нутгийн өмчит компаниудыг бид нар эртхэн цэгцэлж, засаглалынх нь хувьд цэгцлэх төр ямар бизнес хийх, хийхгүйгээ энэ удаагийн парламент хийж дуусгах явдал бол энэ удаагийн парламентын түүхэнд гүйцэтгэх үүрэг ролийн хамгийн том хэсэг нь. Бид нар төрийн болон орон нутгийн өмчит компанийн хуулийг энэ намрын чуулганаар би явуулчихаасай гэж

чин сэтгэлээсээ хүсэж байгаа юм. Яагаад гэвэл энэ хуулийн төслийг санаачилсан хүний хувьд. Тэгэхээр энэ удаагийн сонсгол нь өөрөө энэ ТӨК-уудыг цаашид ийм алдаа эндэгдэл гаргахгүй тогтолцооных нь хувьд шинэчлэх, бүх тэр өмнө нь үйлдэгдсэн, хийгдсэн бүх гэрээ хэлцлүүдийг олон нийтэд ил тод болгоё л гэж байгаа юм.

Тэр байтугай өчигдөр Ерөнхий прокурор ярьсан. БНХАУ-ын прокурорын байгууллагаас манай эрх зүйн харилцан туслалцаа хүссэн зарим асуудлууд дээр ойрын үед зарим эрх зүйн туслалцааны шинжтэй мэдээллүүдийг гаргаж өгье гэдгээ хэлж байгаа юм байна лээ. Тэгэхээр энэ удаагийн сонсгол бол нэг талаасаа шүүх дээр шийдэгдэж байгаа хэргийн талаар олон нийтэд ил тод болгож болох ёстой бүх мэдээллүүд, дээр нь 1995 оноос хойш манай улс анх нүүрсний салбарт экспорт хийж эхэлсэн юм байна лээ. 2005 оноос хойш илүү масс экспортыг хийж эхэлсэн. Үүнээс хойших мэдээ мэдээллүүдийг хэдүүлээ тал талаас нь шинжлэн судалж, юун дээрээ бид нар алдаа оноо гаргасан юм, юун дээрээ энэ ТӨК-уудыг улс төрийн шийдвэр гаргаж, зах зээлийнх нь жамаар хөгжүүлээгүй юм. Цаашид юуг нь засаж залруулах ёстой юм, ямар хэмжээний нүүрс өнөөдөр сох дутчихаад байгаа юм. Таны олон нийтэд анх ил болгосон, мэдээлсэн 40 их наяд төгрөгийн нүүрс үнэхээр дутсан юм уу, эс үгүй бол зах зээл дээр бид нар буруу тогтносноос ийм хэмжээний эрсдэл учирсан юм уу гэдгийг тал талаас нь ил болгож ярья л гэдэг л ийм сонсголыг зохион байгуулъя гэж байгаа юм.

Дээр нь мөрдөн шалгах ажиллагааны явцад дутуу дулимаг хийгдсэн зүйлүүд байвал түүнийг хууль хяналтын байгууллагад шилжүүлье. Нөгөө талдаа би нөгөө үгийнхээ эхэнд хэлсэн. Шүүх засаглалаа илүүтэй хэдүүлээ харилцан нөгөө хяналт тавих, шахаж шаардах энэ боломж бас

парламентын энэ сонсголоор гарч ирнэ гэж найдаж байгаа.

Д.Ганбат: Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Би Доржханд гишүүний асуултад хариулъя. Хэнтэй хөтлөлцөхөө би мэдье. Ийм балай юм битгий ярьж байгаач. Улсын Их Хурлын гишүүн битгий хувь хүн ярьж бай. Асуудлыг ярь. Би түрүүнээс хойш дандаа аудитын дүгнэлт дотор байгаа зүйл заалтуудтай холбож асууж байгаа 1 дүгээрт.

Миний байгуулсан намыг чи толгойлоод явж байгаа. Сайн сайхныг хүсье. Бид 2 тухайн үедээ хөтлөлцөөд л явж байсан. Тэгэхдээ би хэзээ ч хүн муулдаггүй. Хүн ярьдаггүй 1 дүгээр зүйл. Би чамайг юм асууж байхад дуугүй байсан шүү. Би чамайг юм асууж байхад дуугүй байсан шүү.

2 дугаарт. Тэр 40 их наяд гэж яриад байгаа тэр юман дээр чи ард түмнийг төөрөгдүүлж, худал мэдээлэл өгсөн гэдэг дээр дүгнэлтээ хийгээрэй.

3 дугаарт. Шүүхээс өмнө чи өөрөө шийдвэр гаргаж хэн нэгнийг ялладаг энэ тэнэг байдлаа зогсоогоорой. Ингээд Улсын Их Хурлын гишүүний хувьд чамд зарчмын хэдэн зүйлүүдийг ярилаа. Амжилт хүсье ээ.

Д.Ганбат: Тодруулах юм уу. 1 минут.

Т.Доржханд: Ганбаатар гишүүн ээ, та ингээд би хувь хүн ярьдаггүй, асуудал ярьдаг гээд. Би танаас асуудал асууж байна шүү дээ. Бодитой факт асууж байна шүү дээ. Хараат бусаар, чөлөөтөөр ажиллаж чадах юм уу гэхээр ингээд баахан үлгэр яриад л, тойруулаад л хаячихдаг. Та нэг ийм зальтай юмаа больчихооч. Тодорхой юман дээр тодорхой асуулт, хариулт шаардаж байна. Нүүрсний пирамидын тэр толгой гээд байгаа, тэр шийдвэр гаргасан хүн чинь

тухайн үеийн Ерөнхийлөгч байсан. Зугтаасан. Бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ. Одоо энэ асуудлыг хэлэлцэх гээд байна шүү дээ. Гэтэл та тэр хүний өвөрт нь орчхоод л явж байгаа шүү дээ. Үнэн биз дээ. Хөгжлийн банкны асуудал дээр таны 2 асуудал гарч ирсэн шүү. Холбоотой. Хоёулаа баримтаар нотлогдсон шүү. Прокурорын байгууллага дээр очоод л тэр нь гагцхиаад байгаа. Тэр хүн чинь тэрийг цайруулж байгааг би бас мэдэж байгаа. Одоо тэгээд ямар учраас ийшээгээ ингээд чичрээд, би дарга болно гээд байгаа юм бэ. Ямар нэгэн захиалга байгаа юм уу. Тэгээд ийм болохлоор энэ дээрээ хариулчих л даа. Зүгээр эр зоригтойгоор хариулчих л гэж байна шүү дээ.

Д.Ганбат: Асуулт байсан юм уу. Үг байсан юм уу. Ганбаатар гишүүн алив хариулчих.

С.Ганбаатар: Би хараат бусаар өдий хүртэл ажиллаад ирсэн. Ийм хүүхдийн асуултад ингээж л хариулъя даа.

Д.Ганбат: Ганбаатар гишүүнийг асуух цаг дээр нь би бас нэг асуулт байна. Яах вэ, ер нь Хөгжлийн банкны асуудлаар Доржханд гишүүн бид 2 анх санал, санаачилга гаргасан юм. Тэр юмандаа Доржханд гишүүн нэлээн ч идэвхтэй оролцсон байх. Манай бүлгийнхний 3 гишүүн суусан юм. Тэгээд бид бүхнийг бол тэр мэдэх эрхээр, мэдээллээр хангаж чадаагүйг манай бүлгийн дарга хэлж, ярьж байх шиг байна. Тэгээд 1 ийм дутуу хагас болсон. Тэгээд тэр юм битгий давтагдаасай л гэсэндээ л ийм зүйл яриад байна л даа. Би мэдээж хэрэг ном дүрмийнх нь дагуу санал хураалтыг нь явуулаад л, хэн олонхын санал авдаг юм тэрийг нь томилоод л явна.

Би тэр Нямбаатар гишүүний гишүүнийх нь бүрэн эрхэд халдаад байх юм ерөөсөө алга. Зүгээр яах вэ, гүйцэтгэх засаглал, хууль тогтоох засаглал 2 чинь

давхардаад байгаа юм биш үү л гэж ярьж байгаа юм. Яах вэ, бид нарын л хийсэн хуулийн дагуу л явж байгаа байх л даа энэ хүн. Ийм л байгаа. Тэгээд ард түмэн бид нарыг юу ярьж байна, яаж байна гэдгийг нь ялгаж салгаад ингээд ойлгож байгаа нь сайн байгаа байх гэж бодож байна. Ганбаатар гишүүн ээ, та энэ нүүрсний асуудлын энэ түр хороог даргалъя гээд ингээд санал санаачилга гаргаж байгаад би баярлаж байна. Ер нь бас энэ иргэдийнхээ мэдэх эрхийг хангахын төлөө бас ард түмний элчийн хувьд бас ажил хийе гээд өмнөх сонсголууд нь учир дутагдалтай болсон байна. Цөөнх ч байсан, бие даагч ч байсан толгойлоод ингээд ажиллавал ямар байдгийг би харуулъя гэсэн ийм зүйл гаргаж ирж байна гэж ойлголоо. Угаасаа л таны тэр ярьж байгаа тэр эбертийн сан, өнөөдөр олон нийт монголчууд бид нар чинь бүгдээрээ л бас бичиг үсэг тайлагдсан, бас юм хум унидаг барьдаг болчихсон ийм л хүмүүс шүү дээ. Тэгэхээр энэ асуудлыг цөөнх нь сөрөг хүчин нь ингээд авч яваад Улсын Их Хурал дээрээ ард түмний мэдэх эрхийг нь хангаад явчихад энэ ард олон тустай. Энэ Засгийн газарт ч хэрэгтэй, улс орны хөгжилд хэрэгтэй гэдгийг бүгд л ойлгож байгаа, би ч гэсэн тэгж бодож байна. Тэр талаасаа л ярьж байгаа. Энэ түр хороог та толгойлбол ямар үр дүн гарах вэ. Бусад түр хорооноос өөр юу байх вэ. Та юу гэж үзэж байна. Олонх толгойлбол яах вэ. Засгийн газрын гишүүн сайд толгойлбол яах вэ. Та бие даагч хүн толгойлоод ажиллавал ямар байх вэ. Энэ талаар та нэг өөрийнхөө бодлоо ч юм уу, төсөөллөө ч юм уу, үр дүнг нь ч юм уу нэг хэлээдхээч.

С.Ганбаатар: Нүүрсний энэ асуудалд эрх баригчид үе үеийн Засгийн газрууд ялангуяа энэ чинь Хэрэг эрхлэх газрын даргын харьяанд байна лээ шүү дээ. Олон Хэрэг эрхлэх газрын дарга нар, олон сайд, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүд энд оролцож байгаа. Би түрүүн хуудас 47 аудитын дүгнэлтийн 3.10 дээр ингээд биччихсэн

байна лээ гэдгийг бас хэлсэн байгаа. Тэгэхээр ийм асуудал дээр яг Засгийн газар дотор байгаа эрх баригчдын зүгээс асуудалд хурц ширүүн, үр дүнтэй асуудлыг хийхэд бас хүндрэл гарч болзошгүй гэдэг үүднээсээ сөрөг хүчний зүгээс мөнгө мэддэггүй, шийдвэр гаргалтад оролцдоггүй, мөнгө шийддэггүй, зарцуулдаггүй, томилгоо хийдэггүй., сүүлийн 8 жил миний ойлгож байгаагаар Эрдэнэс Тавантолгойн захирлуудыг бүгдийг нь эрх баригчид тавьсан. Өөрийнхөө тавьсан хүмүүстээ өөрсдөө хариуцлага тооцно л гэсэн үг. Энэ илүү хүндрэлтэй, илүү бэрхшээлтэй байх талтай учраас сөрөг хүчнээсээ энийг сонгочихвол арай хараат бус байдлаар ажиллах юм биш үү гэсэн санаа.

2 дугаарт хэрвээ би энийг ахлах юм бол Оюутолгой дээр 20 жил боорлуулж, дээрлхүүлж янз бүрээр дуудууллаа. Оюутолгойн гэрээ дээр бас л хүнийг хатаана шүү дээ. Бас л маш том том мянганы нийтлэлч дээр бөмбөгдүүлнэ шүү дээ. Рио Тинто хэдэн зуун далан тэрбум төгрөг би бүүр баримттай юм ярьж байна. Нэг шилжүүлгээрээ явуулж байсан. Монголын бүх телевизүүдийн рекламн зардлыг 2 дахин нугалсан мөнгөний тийм гүйлгээг хийж байсан тийм тохиолдлуудыг би мэтгэлцээний үеэр бас ярьж байсан л даа. Тэгээд хүнд хэцүү нэг тийм жоохон туршлага байна. Хүмүүсийн итгэл найдвар байна. Үр дүн гаргачихъя л гэсэн санаа. Тэгээд түрүүн би хэлсэн. Яах вэ, яах вэ, би өөрөө ажлын хэсэг тэртээ тэргүй дотор нь ороод ажиллачихна, байдаг тэнхээгээрээ л ажиллана. Зүгээр ганцхан юм байдаг юм. Ажлын хэсгийн ахлагчийн хажуугаар ороод янз бүрийн мэдээлэл ярихад ёс зүйн хувьд ёстой болдоггүй. Надад бол хүнд юм нь тэр. Яг ажлын хэсэг энэ хяналтын хороо, түр хороог ахалж байгаа хүн хэвлэл мэдээлэлд мэдээлэл өгдөг, баримт мэдээллүүдийг тодорхой хэмжээгээр өгдөг. Яг энэ түр хороонд ажиллаж байгаа гишүүд тэр ахалж байгаа

хүнийхээ хажуугаар ороод, зэрэгцээд мэдээлэл өгөх нь хэдий хууль дүрэмд бүр болохгүй гэж заагаагүй ч гэсэндээ тэр хүнд байдаг. Энэ утгаараа арай жоохон эрх чөлөөтэй, нээлттэй ажиллах болов уу гэсэн тийм бодол байна. Ингээд гишүүд олонхоороо шийднэ ээ. Дарга, цэрэг, больё гээд байгаа юм биш, хариуцлага үүрье, монголчууд энэ нэг юм гайгүй шиг шийдчихээсэй гэж горьдож харж байгаа байх. Цул хардлага дундуур явдаг ажил шүү дээ. Энэ бол бүр сайн хийсэн ч балбуулах ёстой ажил. Аймишигтай ажил энэ бол. Сүхбаатар гишүүн ерөөсөө байдаг хүчээрээ ажиллаад байгаа чинь тэр түгжэрэл дээр бас л үр дүн гарч байгаа гэхдээ тэр чинь уул овоо шиг л юм байгаа шүү дээ. Тэгэхээр зүгээр зоригтой л хүний хийдэг ажил гэдэг утгаараа би энийг хэлж байгаа юм шүү. Тэрнээс биш би ингэнэ тэгнэ гээд нэг их тийм дарга болох гээд л аймар их мэтгэлцээд яриад яах вэ. Баримтуудаа түшиглэнэ. Аудит харин сайн ажилласан юм шүү. Энэ аудит ёстой сайн материал байна лээ. Дээр нь тэр 2 портёр дүүрэн материалуудыг 6 сар бас уничихсан юм байна. Арай жоохон шууд ажил руугаа орох болов уу л гэсэн санаа байсан. Ингээд гишүүд шийдвэрээ гаргана биз ямар ч байсан Монголын ард түмэн харж байгаа. Энэ дээр бид хариуцлагатай ажиллах ёстой гэдэг байр суурьтай байна.

Д.Ганбат: Ерөнхий дөө Улсын Их Хурал маань анх удаагаа түр хороонууд байгуулаад ажиллаж байгаа шүү дээ. Мөрдөн шалгах энэ хууль батлагдаад. Өмнөх анхны түр хороо бас нэлээд сайн ажилласан гэж бодож байгаа. Үр дүн нь ямар байсныг бүгдээрээ л дараа нь ярих байх. Дараагийн Нүүрсний түр хороо манай Ганболд гишүүнээр ахлуулаад байгуулсан. Тэр маань бас нэг хүлээлтэд хүрч чадаагүй юм уу, бас ямар саад байсан юм ийм байдалтай болчихлоо. Одоо бид бүхэн мэдээж хэрэг баахан ард түмний хөрөнгийг шамшигдуулсан хөгжлийг гацаасан энэ бүх зүйлийг энэ түр хороо дээр ярьж ард түмний мэдэх эрхийг хангах байх. Энэ дээр бид нар

уурлаж уцаарлаад ингэж барилгүйгээр нэг аятайхан шиг явмаар байгаа юм. Хэн уурлуулж чадаж байна, тэр хүнийг удирдаж чадаж байна л гэж яриад байдаг шүү дээ. Тэгэхээр эрх мэдэлтэй хүмүүс жоохон бас биеэ барьж, ард түмэндээ хүндэтгэлтэй хандана. Улсын Их Хурлын гишүүнд ямар хандана гэдэг чинь цаана нь байгаа сонгогчид, ард түмэнд тэгж хандаж байна л гэсэн үг шүү дээ. Бүгдээрээ л бид нар ард түмний элч, төлөөлөгчид энд сууж байгаа гэдгийг бас хэлье. Асуугаад байх юм алга.

Ингээд хурлынхаа дарааллын дагуу дараагийнхаа асуудал оръё. Ингээд санал хураалт Нямбаатар гишүүн, Ганбаатар гишүүн 2 нэр дэвшсэн байна. Ингээд Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Нямбаатарыг Нүүрсний сонсголын түр хорооны даргад нэр дэвшүүлснийг дэмжье гэдгээр санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Ингээд олонхын санал авсан хүн энэ түр хорооны даргаар сонгогддог. Санал хураалтынхаа дүнг танилцуулъя. Ингээд нийт 9 гишүүн оролцож, 5 гишүүн дэмжиж, 4 гишүүн татгалзаж, 55,6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны тогтоолын төслийг танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны тогтоол.

2023 оны 8 дугаар сарын 29-ний өдөр. Улаанбаатар хот. Түр хорооны даргыг сонгох тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.5 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсэг, 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын 2023 оны 63 дугаар тогтоолоор байгуулагдсан Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос тогтоох нь.

Нэг.Төрийн болон орон нутгийн өмчит өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил үйлчилгээ, худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Хишгээгийн Нямбаатарыг сонгосугай.

Хоёр.Энэ тогтоолыг 2023 оны 8 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Хуралдаан даргалагч гэсэн байна. Тогтоолын төсөлтэй холбогдуулаад саналтай, асуулттай гишүүд байна уу. Ганбаатар гишүүн байн. Ганбаатар гишүүнээр тасаллаа. Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Ажлын хэсэг Монголын ард түмэн тэр чигээрээ харж байгаа их чухал хариуцлагатай. Тэгээд ажлын хэсгийн гишүүд бид бас ганцхан ахалж байгаа хүн дээрээ бүх юмаа лаахайдаж хаячхаад хараад байж болохгүй. Бүгдээрээ идэвхтэй бас ажиллах ёстой. Тэгээд би тогтоолын төсөлд 3 санаа оруулмаар байна.

1 дүгээрт энэ том хулгай тэртээ тэргүй гарчихсан. Энэ хулгайн эрх зүйн орчны үр дагавруудыг хууль, эрх зүйн дүгнэлт өгч, эрх зүйн орчны тэр хулгай гарна гэдэг тэнд чинь бас эрх зүйн тэр цоорхой байгаад байна шүү дээ. Гааль нь өнөөдөр энд хулгай байна гээд цагдаад мэдээлээд байхад 2 удаа энийг бүр хэрэгсэхгүй болгосон. Тэгээд сая энэ өндөр авсан чинь буцаагаад хэрэг үүсгэсэн л дээ. Ингэхээр 1 дүгээрт эрх зүйн нөхцөл дээр энэ дахиж гарахгүй байх үүд хаалга тэр эрх зүйн орчныг бий болгох.

2 дугаарт нэгэнт хохирол гарлаа хэдэн хүнийг хариуцлага тооцлоо гэж байсан ч гэсэн ард түмэнд ямар хохиролгүй болгох вэ. Тэр олон их наяд төгрөгийн хохирлыг яаж төлүүлэх вэ гэдэг тодорхой байх ёстой. Тэгэхгүй зүгээр хэдэн хүнийг шоронд хийгээд бид цадахгүй шүү дээ. Энэ чинь уул уурхайн баялаг асар их зөөгдөөд, ард, иргэдийн амьдрал одоо энэ аудитын дүгнэлт дээр байж байгаа юм. Бүр маш сайн бичсэн байна лээ. 987 мянган хүн буюу 1 сая орчим хүн ядуу амьдарч байна. Уул уурхайн баялаг нь нэмэгдээд, зөөгөөд байгаа мөртөө хүмүүс нь ядуурал нь ихсээд байна гэдэг чинь хулгайч нар гараад байна л гэсэн үг. Тэгэхээр буцаагаад энэ хохирлыг яаж нөхөн төлүүлэх вэ.

3 дугаар зүйл. Би түрүүн ярилаа. Жижиг хувьцаа эзэмшигчид 1072 гээд байгаа тэр хүмүүсийн эрх зүйн орчныг шинэ шатад гаргаж хяналт тавьдаг, шийдвэрт оролцдог, бас тэр хувьцааны үр ашгаас хүртдэг байх тэр эрх зүйн орчныг бүрдүүлэх гэсэн ийм 3 зүйлийг би энэ удирдамж дээр бас оруулмаар байна.

Д.Ганбат: Өнөөдрийн түр хорооны даргаар 2 хүн нэр дэвшүүлсэн Ганбаатар гишүүн, Нямбаатар гишүүн. Нямбаатар гишүүний санал хураалт 50-аас дээш олонхын санал авсан учраас Ганбаатар гишүүнийг саналыг нь хураалгасангүй шүү гэдгийг бас протоколд тэмдэглүүлбэ.

Энэ тогтоолыг батлахыг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя. Олонхын саналаар тогтоолын төсөл батлагдлаа.

Ингээд түр хорооныхоо даргыг урья.

Х.Нямбаатар: Баярлалаа түр хорооны даргаар итгэл хүлээлгээж сонгосон гишүүддээ баярлалаа. Тэгээд манай түр хороо төрийн болон орон нутгийн өмчит төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой

компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ, худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд 2023 оны намрын чуулгандаа багтааж танилцуулах ийм үүрэг бүхий түр хороо ажлаа эхлүүлж байна. Тэгээд энэ хянан шалгах түр хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг хэдүүлээ нэлээн шуурхайлан явцаага гэдэг ийм саналыг та бүхэндээ оруулж байна.

Тэгээд өнөөдрийн хуралдаан хэлэлцэх асуудлаа шийдвэрлэж дууссан тул хурлаа өндөрлөе.

Ирэх 7 хоногт багтаж түр хороо хуралдана. Хуралдаанаар хэлэлцэх асуудлын тов хэлэлцэх асуудлын дарааллыг ажлын албанаас та бүхэнд энэ 7 хоногтоо багтаагаад хүргүүлнэ. Бид нар ер нь нэлээн шуурхай ажиллах байгаа. 9 сард бид нэлээд шахуу ажиллаад, мэдээллүүдээ цуглуулсныхаа үндсэн дээр сонсголоо зохион байгуулах ийм шаардлага байна. Дээр нь бид нар бас Эрдэнэс Тавантолгой, жижиг 5 толгойн үйл ажиллагааг газар дээр нь бас очиж үзэх шаардлагатай байгаа. Энэ дээр мэргэжлийн геологи маркшейдерийн мэргэжилтнүүдийг бас аваачиж үзүүлбэ гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа. Энд нэг ноцтой асуудал байгаа. Сая тэр тайланд дурдагдсан асуудал байгаа юм. Энэ бизнесийнхээ жамаар яваагүйгээс болоод хэд хэдэн ноцтой алдаанууд гараад байгаа. Тэрний нэг нь юу вэ гэвэл бид нар нөгөө Баруун, Зүүн цанхаа төд удалгүй бид нар илээр биш далд хэлбэр лүү уурхайн өөрийнх нь нөгөө олборлолтын өртөг өндөрсөх ийм нөхцөл байдал руу хүртэл шилжчихээд байгаа юм. Тэгэхээр энэ бүх гарсан алдаануудыг хэдүүлээ тал бүрээс нь бас судалъя. Ойрмогхон 9 сардаа багтаад талбай дээр 1 өдөр

ажиллагчхаад буцаж ирье гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа.

2 дугаарт тэр нөгөө боомтуудын нэвтрэн өнгөрөх чадварууд дээр газар дээрээ ямархуу байдалтай байгааг хэдүүлээ бас үзье. Тээвэрлэлт одоогийн нөгөө “С” зөвшөөрлийн тоо хэмжээг багасгаад тендер зарлаад тээвэрлэлтийг явуулж байгаа Цагаан хадны нафтын талбай дээр ямархуу нөхцөл байдлууд байгаа гэдгийг хэдүүлээ газар дээр нь бас очиж үзье гээд ийм төлөвлөгөөтэй байгаа. Би ажлын албаныхантай ярьж байгаад энэ асуудлаар ирэх 7 хоногт хэдүүлээ ганцхан өдөр ерөөсөө өглөө 8 цагт яваад, орой 8 цагт буцаад ирэхээр ийм төлөвлөсөн байгаа. Энийг ирэх 7 хоногийн 2 дахь өдөр амжуулчихвал та бүхэнд цаг зав ямар байхаар байна. Та хэд нэг эргэж хэлээрэй.

Би болж өгвөл бүрэлдэхүүн олуулаа л явбал их сайн байна. Тэгээд би энэ дээр нөгөө гол нь яг манай ТӨК-д ажилладаг хүмүүсээс гадна мэргэжлийн яг нөгөө уулын ажлын төлөвлөгөө баталдаг яг мэргэжлийн хүмүүсийг хувийн секторт ажилладаг хүмүүсийг аваачиж газар дээр бас нэг энэ уурхайн явцын талаар үзүүлье. Ер нь бид нар ингээд л яриад байгаа юм. Гэтэл ерөөсөө 2005 оноос хойш энэ олборлолт эхэлсэн юм байна лээ. Тэгээд нөгөө баруун, зүүн цанх чинь ерөөсөө хэдхэн жилийн дараа гүн рүү шилжихээс өөр аргагүй болчихоод байгаа юм. Гэтэл тэр яг нөөц дээрээ отвалыг асгах шийдвэрийг хэн олгосон юм, тэрэнд хэн хяналт тавьж байсан юм гээд л ийм юмнуудыг хүртэл тал талаас нь үзье.

Дээр нь мөрдөн шалгах ажиллагааны явцад цуглараад байгаа баримт сэлтүүдийг бид нар бас прокурорын байгууллагатай ярилцаж байгаад түр хороо дээрээ бүгдтэй нь танилцуулаад, та бүхэн хуулбарлаж авах боломжтой юмнуудаа ярьж байгаад эндээс аль алийг хэдүүлээ олон нийтэд сонсох ёстой юм бэ гэдгээ ярья гэсэн ийм

2 ажлыг энэ 9 сарын эхний 10 хоногт багтааж хийгээдэхье гэсэн. Тэгээд би та бүгдийг боломжоороо л та бүхнийг оролцоод байгаач ээ, би нэлээн шахуу ажиллая. Одоо яагаад гэвэл олон шүүмжлэл байгаа шүү дээ. Чи муу олон ажлын хэсэг ахалчаад, тэгээд энэ ажлыг цалгардуулах вий гэдэг шүүмжлэлд өртөхгүйн тулд би нэлээн шахуу шиг ажиллая. 9 сарын эхний 10 хоногт 2 ажил амжуулах гээд байна.

Нэг нь газар дээр нь очиж мэргэжлийн уул уурхайн мэргэжилтнүүдтэй ажиллах,

2 дахь нь нөгөө юуг сая үзье гэсэн шүү дээ. Хууль хяналтын байгууллагуудын шалгалтын явцын талаар хэдүүлээ мэдээллийг сонсоод, тэгээд аль алийг энэ сонсголд татаж оролцуулах юм. Зарим хэрэгт бүр холбогдоод хоригдож байгаа шалгаж байгаа хүмүүсийг хүртэл хэдүүлээ энд сонсголд дээр оруулж ирж сонсгож яриулмаар байгаа байхгүй юу. Бас хэдүүлээ нэг өнцгөөс баймааргүй байна. Тэр хүн бас өөрийгөө юу ярих ёстой юм өөрсдөө бас ярих, хэлэх үгнүүд байгаа шүү дээ. Энэ зүйлүүд дээр бид нар гарцаагүй ингээд хавчигдаж, шахагдаад энэ ажлууд явснаас болж өнөөдөр ийм алдаа эндэгдэл гарсан гэдэг. Тэгэхээр 9 сарын эхний 10 хоногт 2 зүйлийг хэдүүлээ түр хороо дээрээ ярьчихъя. За Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Түр хорооны даргын саналыг сая сонслоо. Би зүгээр санал хэлэхэд 1 дүгээрт бие даасан хөндлөнгийн шинжээчтэй гишүүд нөгөө талбай дээр очихоосоо өмнө тодорхой болгоод албан ёсжуулбал их сайн гэж би үзэж байна. Бие даасан хөндлөнгийн шинжээчид. Та түрүүн Геодезийн, маркшейдерийн хүмүүс ярих шиг боллоо. Ингээд тэр шинжээчдээ тогтоод болчихвол 1 дүгээрт сайн байна.

2 дугаарт тийшээ очиход би хальт маркшейдер геодезиор сурч байсан

төдий амьтан гэхэд л юу ч мэдэхгүй шүү дээ. Бид мэдэхгүйгээ мэдэх ёстой. Тэгэхээр тэр хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлтийг гаргуулахад дэмнэх ажил санал болж байна. 2 дугаарт энэ өнгөрсөн Ганболд гишүүний ахалсан ажлын хэсэг дээр их сэтгэл гаргаж ажилласан бид нар. Тэгэхээр тэр дээр ажилласан 5 шинжээч байгаа. Ажлын албаныхан орчих байх л даа, ажиллах байх. 5 шинжээчийг бас та уулзаж үзээд энд оруулбал шууд асуудлаа мэддэг сайн байх болов уу гэсэн тийм саналыг би хэлж байна. Энийг ингээд бас ажилдаа тусгаж.../минут дуусав/

Х.Нямбаатар: *Ойлголоо. Ер нь бол яг саяын хэлсэн шинжээчийг бид нар удахгүй шалгаруулах, түүнийгээ хамтраад батална. Манай энэ ажлын албаныхнаас хэлж байна. Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дуусчихсан учраас дахиж үргэлжлүүлж ярих дэггүй гэж байгаа учраас өнөөдрийн хурлаа өндөрлөе. Хэлэлцэх асуудал дууслаа.*

13.00 цаг.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ